



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 5 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.1, 26.1.7, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.1, 7.1.24, Улсын онцгой комисс, Сонгуулийн өрөнхий хорооны саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн маягт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан журмыг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд үүрэг болгож, Сонгуулийн өрөнхий хороо (П.Дэлгэрнаран)-нд зөвлөсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН

УХА0064



Засгийн газрын 2021 оны 152 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
ҮЕД КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааны үед коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч, сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, түүний менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч, сонгуулийн хороодын ажилтан, иргэд сонгуулийн үйл ажиллагааны үед Сонгуулийн тухай хууль тогтоомж, Эрүүл мэндийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Олон улсын эрүүл мэндийн дүрэм болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3. Төрийн байгууллага, сонгуулийн хэсгийн хороо сонгуулийн үйл ажиллагааны үед энэ журмын 1.2-т заасан хууль тогтоомж, журмыг нэгэн адил дагаж мөрдөнө.

Хоёр. Баримтлах зарчим

2.1. Сонгуулийн үйл ажиллагааны үед коронавируст халварын цар тахлаас урьдчилан сэргийлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.1.1. хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх;

2.1.2. ил тод, хариуцлагатай байх;


2.1.3. ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх;

2.1.4. байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах;

2.1.5. хүний нэр төрийг хүндэтгэн харьцах.

Гурав. Сонгуулийн сурталчилгааны үед халдвараас сэргийлэх үйл ажиллагаа

3.1. Сонгуулийн сурталчилгааны үед аливаа арга хэмжээ, сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах байр, танхимыг урьдчилан цэвэрлэж, халдвартай хийсэн байна. Оролцогч бүр амны хаалт заавал зүүх бөгөөд хүн хоорондын зайд 1.5 метрээс доошгүй байж, биеэр хүрэлцэхгүй (гар барих, тэврэх, үнсэх) зайнласаас харьцаана.



3.2.Уулзалт, хурал, цуглааныг зохион байгуулах байр, танхим болон гадна талбайд оролцогчдын сандлыг заавал байрлуулах бөгөөд суудал хоорондын зайд 1.5 метрээс доошгүй байна.

3.3.Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хурал, цуглаан хийх байр, нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт цугларсан оролцогчдын биеийн халууныг зайнас хэмжиж, гарыг халдвартгуйжүүлэх ажлыг тухайн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч хариуцна.

3.4.Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орон нутгийн газарт зохион байгуулах уулзалт, хурал, цуглаанд оролцогч хоорондын зайд 1.5 метрээс доошгүй байна.

3.5.Сонгуулийн сурталчилгаа явуулах байр, танхимд орох, гараад иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулна.

3.6.Сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглааныг ил задгай талбай, танхимд хийх бөгөөд уулзалт, хурал, цуглааныг богино цагаар (нэг удаагийн уулзалт, хурал, цуглаан 2 цагаас хэтрэхгүй) зохион байгуулна.

3.7.Уулзалт, хурал, цуглааны танхимиын салхивч, хаалгыг 30 минут тутамд 10 минутаас доошгүй хугацаагаар нээж, өрөө тасалгааг агааржуулна.

3.8.Уулзалт хооронд хүний гар хүрэлцдэг ширээ, индэр, сандал, цонхны тавцан, хаалга зэрэг хатуу гадаргууг ахуйн хэрэглээний халдвартгуйжүүлэх бодисоор сайтар цэвэрлэнэ.

3.9.Хаалга, явган болон урсдаг шатны бариул, цахилгаан шатны товчуур, компьютер, хэвлэгч, хувилагч, утас зэргийг 2 цаг тутамд халдвартгуйжүүлэх бодисоор шүржиж, сайтар арчиж цэвэрлэнэ.

3.10.Уулзалт, хурал, цуглааны танхимд ашиглаж байгаа микрофоныг 2 цаг тутам спиртэн суурьтай уусмалаар арчиж цэвэрлэж, эсхүл нэг удаагийн уут хэрэглэнэ.

3.11.Танхимд уулзалт, хурал, цуглаан эхлэхийн өмнө болон дараа чийгтэй цэвэрлэгээ хийж, агаарыг сэлгэж, тоног төхөөрөмж, хэрэгслийг сайтар цэвэрлэнэ.

3.12.Уулзалт, хурал, цуглаанд амны хаалтгүй хүн оролцуулахыг хориглоно.

3.13.Халуунтай, ханиалгах, бөөлжих зэрэг шинж тэмдэгтэй хүнийг уулзалт, хурал, цуглаанд оролцуулахгүй бөгөөд эмнэлэгт хандахыг зөвлөж, гэрт нь буцаана.

3.14.Сонгогч амны хаалтгүй тохиолдолд 1 ширхэг амны хаалтаар хангаж болох бөгөөд амны хаалт сурталчилгааны шинжтэй байхыг хориглоно.

3.15.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг тараах үед нэг удаагийн бээлийн өмсөнө.



3.16. Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг айл өрхөд тараахаар бол гэр бүлийн гишүүдтэй харьцахгүйгээр, хаалганы гадна талд үлдээнэ.

3.17. Нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд уулзалт, хурал, цуглаан хийсэн газар, цаг хугацаа, оролцсон хүний баримжаа тоо, сурталчилгаа хийж явсан маршрутыг (замын зураглалыг) нотолсон бүртгэлийг хөтөлж, гэрэл зураг, эсхүл дүрс бичлэгээр баримтжуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд уг мэдээллийг эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.18. Сонгуулийн сурталчилгаа, уулзалт, арга хэмжээнд сонгуулийн насанд хүрээгүй хүн оролцуулахыг хориглоно.

3.19. Хэрэглэсэн амны хаалт болон бусад хог хаягдлыг зориулалтын хогийн уутанд цуглуулан, уутны амыг боож, зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяна.

**Дөрөв. Ухуулах байранд халдвараас
сэргийлэх үйл ажиллагаа**

4.1. Ухуулах байранд амны хаалтгүй хүн оруулахыг хориглох бөгөөд уг байранд ажиллаж байгаа хүн бүр амны хаалт зүүсэн байна. Амны хаалтгүй ирсэн иргэнд 1 ширхэг амны хаалт олгох бөгөөд амны хаалт нь сурталчилгааны шинжтэй байхыг хориглоно.

4.2. Ухуулах байранд орох хүний биеийн халууныг зайнаас хэмжиж, гарыг спиртэн суурьтай уусмалаар халдвартгуйжүүлнэ.

4.3. Ухуулах байранд ажиллагчдын биеийн халууныг өдөрт 2-оос доoshгүй удаа зайнаас хэмжиж, бүртгэнэ.


4.4. Ухуулах байранд иргэд хоорондоо биеэр хүрэлцэхгүй (гар барих, тэврэх, үнсэх), хүн хооронд 1.5 метрийн зайд барьж харьцана.

4.5. Ухуулах байранд иргэдийг суулгах сандлыг заавал байрлуулах бөгөөд тэдгээрийн хоорондын зайд 1.5 метрээс доoshгүй байна.

4.6. Ухуулах байранд чийгтэй цэвэрлэгээг 2 цаг тутамд хийж, 30 минут тутамд 10-аас доoshгүй минут агаар сэлгэнэ. Ухуулах байрны гадна талбайг тогтмол цэвэрлэнэ.

4.7. Ухуулах байранд ажиллаж байгаа хүн нэг удаагийн бээлий өмсөх бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэж дуусмагц хэрэглэсэн бээлийг хогийн уут, саванд хаяна.

4.8. Хэрэглэсэн амны хаалт, бээлий болон бусад хог хаягдлыг хогийн уутанд цуглуулж, уутны амыг боож, зөвшөөрсөн хогийн цэгт хаяна.



Тав.Нам, эвсэл, нэр дэвшигчийн эрх, үүрэг

5.1. Нам, эвсэл, нэр дэвшигч дараахь эрхтэй:

5.1.1.коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, сахин биелүүлбэл зохих арга хэмжээний талаар эрх бүхий байгууллагаас мэдээлэл, зөвлөгөө авах;

5.1.2.эрх бүхий байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

5.1.3.коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар эрх бүхий байгууллагад санал, хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх.

5.2. Нам, эвсэл, нэр дэвшигч нь дараахь үүрэгтэй:

5.2.1.сонгуулийн үйл ажиллагааны үед мэргэжлийн байгууллагаас коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар гаргасан журам, заавар, зөвлөмж, сэрэмжлүүлгийг сахин биелүүлэх;

5.2.2.ухуулах байр, уулзалт, сурталчилгааны үед коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажилтныг томилох;

5.2.3.коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбогдон гарах зардал (амны хаалт, гар халдвартгүйжүүлэгч, халуун хэмжигч гэх мэт шаардлагатай)-ыг хариуцах.

Зургаа. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах үед халдвараас сэргийлэх үйл ажиллагаа

6.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан сонгогчоос зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авна.

6.2.Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаанд сонгуулийн хэсгийн хорооны ажилтан, ажиглагч, цагдаагийн алба хаагч оролцоно.

6.3.Санал авах ажиллагаанд оролцож байгаа хүмүүс хооронд 1.5 метрийн зайд барина.

6.4.Сонгуулийн хэсгийн хорооны ажилтан гар халдвартгүйжүүлэгчийг хариуцан авч явах бөгөөд санал авахын өмнө болон дараа оролцогчдын гарыг халдвартгүйжүүлнэ.

6.5.Сонгогч болон санал авах ажиллагаанд оролцогч бүр амны хаалт зүүж, нэг удаагийн бээлий өмсөнө. Санал авах ажиллагааг зохион байгуулагчид нэг удаагийн улавч өмсөнө.

6.6.Санал тэмдэглэх үзэг, зөөврийн бүхээг, зөөврийн битүүмжилсэн хайрцгийг санал хураалт бүрийн дараа спиртэн суурьтай халдвартгүйжүүлэгч уусмалаар арчиж цэвэрлэнэ.

6.7.Хэрэглэсэн амны хаалт, бээлий болон бусад хог хаягдлыг хогийн уутанд цуглуулж, уутны амыг боож, зөвшөөрсөн хогийн цэгт хаяна.

6.8.Өөрийн байнга оршин суугаа аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа дараах сонгогчийн саналыг санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар авна:

6.8.1.Короновируст халдвартын улмаас хэвтэн эмчлүүлж байгаа сонгогч;

6.8.2.Улсын онцгой комиссын даргын 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 31 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын дагуу тусгаарлагдсан сонгогч;

6.8.3.Энэ журмын 6.8.1, 6.8.2-т заасан үйл ажиллагаатай холбоотойгоор тухайн тусгаарлах байр, эмнэлэгт тусгай чиг үүргийн дагуу ажиллаж байгаа эрүүл мэнд, цагдаа, онцгой байдлын зэрэг албан хаагч;

6.8.4.Улсын онцгой комиссын даргын 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 31 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Гэр (амрах байр)-ийн тусгаарлалт, ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын дагуу тусгаарлагдсан сонгогч.

6.9.Энэ журмын 6.8.1, 6.8.2, 6.8.3-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар санал өгөх хүсэлтээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 58.4-т заасны дагуу санал авах өдрөөс 7-оос доошгүй хоногийн өмнө батлагдсан маягтын дагуу тухайн тусгаарлах байр, эмнэлгийн захиргаанд гаргана.

6.10.Энэ журмын 6.8.4-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар санал өгөх хүсэлтээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 58.2-т заасны дагуу санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө өөрийн харьяа хэсгийн хороонд гаргана.

6.11.Энэ журмын 6.8.4-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар саналаа өгөх хүсэлт гаргахад тухайн сонгогчийн харьяалагдах баг, хорооны Засаг дарга түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

6.12.Тусгаарлах байр, эмнэлгийн захиргаа энэ журмын 6.8.1, 6.8.2, 6.8.3-т заасан сонгогчийн хүсэлтийг хүлээн авч нэгтгэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 58.4-т заасны дагуу санал авах өдрөөс 7-оос доошгүй хоногийн өмнө тухайн тусгаарлах байр, эмнэлгийг нутаг дэвсгэрийн хувьд харьяалах сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

6.13.Энэ журмын 6.12-т заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг сум, дүүргийн сонгуулийн хороо санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө тухайн сонгогчийн харьяалагдах хэсгийн хороонд хүргүүлнэ.

6.14.Энэ журмын 6.13-т заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан хэсгийн хороо болон түүний дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтан дараах ажиллагааг хийнэ:

6.14.1. тухайн хэсгийн сонгогч мөн эсэхийг итгэмжлэгдсэн ажилтны оролцоотойгоор нягтлан шалгах;

6.14.2. зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн нэрсийг гаргаж, хэсгийн хорооны дарга зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах хуваарь, чиглэлийг батлах;

6.14.3. аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах хуваарь, чиглэлийг батлахдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 58.1-д заасан хугацаатай уялдуулан тооцох бөгөөд ирэх, буцах цаг хугацаа, туулах замын зайнаас шалтгаалан хуульд заасан хугацаанд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэх.

6.15. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн хэсгийн хорооны даргын баталсан хуваарь, чиглэлийн дагуу тухайн сонгогчийн оршин байгаа газар буюу тусгаарлах байр, эмнэлэгт очиж авна.

6.16. Энэ журмын 6.8.1, 6.8.2, 6.8.3-т заасан сонгогч бүхий эмнэлэг, тусгаарлах байрыг нутаг дэвсгэрийн хувьд харьяалах хэсгийн хорооны дарга тухайн эмнэлэг, тусгаарлах байранд сонгогчоос санал авах ажиллагааг зохион байгуулах хоёр гишүүнийг томилон ажиллуулна.

6.17. Энэ журмын 6.9-д заасны дагуу хүсэлт гаргасан сонгогчийн харьяалах хэсгийн хорооны гишүүн энэ журмын 6.16-д заасны дагуу томилогдсон сонгуулийн байгууллагын ажилтанд дараах зүйлсийг хүлээлгэн өгнө:

6.17.1. зөөврийн хайрцаг, санал тэмдэглэх зориулалт бүхий үзэг, нэг удаагийн бээлий, саналын хуудасны тусгай зориулалт бүхий хавтас;

6.17.2. хүсэлт гаргасан сонгогчийн тоонд үндэслэн дахин нэг удаа саналын хуудас өгөх нөөцтэй байхаар тооцсон саналын хуудас;

6.17.3. энэ журмын 6.14.2-т заасны дагуу үйлдсэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалт.

6.18. Энэ журмын 6.16-д заасны дагуу томилогдсон сонгуулийн байгууллагын ажилтан сонгогчоос санал авах ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

6.18.1. энэ журмын 6.17.3-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг үндэслэн тухайн сонгогчийн байрлаж буй тусгаарлах өрөөнд нэвтрэхгүйгээр санал тэмдэглэх зориулалт бүхий үзэг, нэг удаагийн бээлий, саналын хуудасны тусгай зориулалт бүхий хавтсыг сонгогчид өгнө;

6.18.2. сонгогч саналын хуудсыг тусгай зориулалтын хавтаснаас гаргаж, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагт хийнэ;

6.18.3. санал өгсөн сонгогчоор энэ журмын 6.14.2-т заасны дагуу хүлээн авсан сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна;

6.18.4.сонгогч биеийн эрүүл мэндийн байдлын улмаас тусгаарлах өрөөнөөс гарч саналаа өгөх боломжгүй тохиолдолд тусгаарлах өрөөнд нэвтэрч санал авах ажиллагааг зохион байгуулна.

6.19.Энэ журмын 6.14.2-т заасны дагуу хүлээн авсан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдоос санал авах ажиллагааг зохион байгуулж дууссан тухай бүрд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, саналын хуудас болон сонгогчдын нэрийн жагсаалтыг нийслэлд Зооноз өвчин судлалын үндэсний төв, аймагт Зоонозын өвчин судлалын төв, Зоонозын өвчин судлалын төвгүй аймгийн Эрүүл мэндийн газар холбогдох тусгайлсан журмын дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт дор халдвартгуйжүүлж, энэ журмын 6.17-д заасны дагуу хүлээлгэн өгсөн хэсгийн хорооны гишүүнд буцааж хүлээлгэн өгнө.

6.20.Хэсгийн хороо энэ журмын 6.19-д заасны дагуу халдвартгуйжүүлсэн саналын хуудсыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу санал тоолох төхөөрөмжид уншуулна.

6.21.Энэ журмын 6.8.4-т заасан сонгогчоос санал авах ажиллагааг зохион байгуулах хэсгийн хорооны бүрэлдэхүүн хүсэлт гаргасан сонгогчийн оршин байгаа газарт нэвтрэхгүй бөгөөд саналын хуудсыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу санал тоолох төхөөрөмжид уншуулна.

Долоо.Санал авах байранд сонгогчийг халдвараас
сэргийлэх үйл ажиллагаа

7.1.Санал авах байранд сонгогчийн санал авах үед халдвараас сэргийлэх үйл ажиллагааг сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүн, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн даамал, үйлчлэгч, ажиглагч болон мэргэжлийн хяналт, цагдаа, онцгой байдал, эрүүл мэнд, нутгийн захиргааны байгууллагын алба хаагч нар хамтран зохион байгуулж, хяналт тавина.

7.2.Санал авах байрыг урьдчилан цэвэрлэж, халдвартгуйжүүлсэн байна.

7.3.Санал авах байранд орох, гараад иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулна.

7.4.Сонгогч амны хаалттай ирж саналаа өгөх бөгөөд сонгогч санал авах байранд орох үед биеийн халууныг зайнаас хэмжиж, гарыг зориулалтын бодисоор халдвартгуйжүүлнэ.

7.5.Санал авах байрны дотор болон гадна хүн хоорондын зайд 1.5 метрээс доошгүй байхаар зохион байгуулна. Оролцогчид биеэр хүрэлцэхгүй (гар барих, тэврэх, үнсэх) зайнаас харьцана.

7.6.Сонгогч гарын хурууны хээг уншуулж, гарыг дахин халдвартгуйжүүлсний дараа олгосон бээлийг өмсөж саналаа өгнө.

7.7.Сонгогч бүртгэл хийлгэх үед амны хаалтыг түр авна.

7.8.Сонгогч санал авах байранаас гараадаа бээлийг зориулалтын хогийн уут, саванд хаяж, гарыг халдвартгуйжүүлнэ.



7.9. Санал авах байрны салхивч, хаалгыг 30 минут тутам 10 минутаас доошгүй хугацаанд нээж, агаар сэлгэнэ.

7.10. Санал авах байранд хүний гар хүрэлцдэг ширээ, сандал, хаалга, цонхны тавцан, бариул зэрэг хатуу гадаргууг 2 цаг тутам халдвартайжүүлэх бодисоор сайтар цэвэрлэнэ. Ухуулах байрны гадна талбайг тогтмол цэвэрлэнэ.

7.11. Санал авах байрны хаалга, явган болон урсдаг шатны бариул, цахилгаан шатны товчлуур, компьютер, хэвлэгч, хувилагч, утас зэргийг 2 цаг тутам халдвартайжүүлэх бодисоор цэвэрлэнэ.

7.12. Санал авах байранд сонгуулийн насанд хүрээгүй хүн дагуулж ирэхийг хориглоно.

7.13. Хэрэглэсэн амны хаалт, бээлий болон бусад хог хаягдлыг зориулалтын хогийн уутанд цуглувлан, амыг нь боож, зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяна.

Найм. Сонгуулийн сурталчилгаа, санал авах ажиллагааны явцад
сэжигтэй тохиолдолд илэрсэн үед авах арга хэмжээ

8.1. Халуурах, ханиалгах, бөөлжих, гүйлгэх, толгой, булчин өвдөх зэрэг шинж тэмдэг илэрсэн хүнийг сэжигтэй тохиолдол гэж үзнэ.

8.2. Сэжигтэй тохиолдлыг мэдээлэх, тусгаарлах арга хэмжээ авах үүрэг бүхий ажилтанг ухуулах байранд болон сонгуулийн сурталчилгааны үед нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч, санал авах байранд сонгуулийн хэсгийн хорооны дарга урьдчилан томилно.

8.3. Танхим болон нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт илэрсэн сэжигтэй тохиолдлыг бусдаас 8-10 метрийн зайд тусгаарлана.

8.4. Санал авах байр сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах өрөөтэй байна.

8.5. Сэжигтэй тохиолдлын талаар Улсын онцгой комиссын Шуурхай штабын 119 дугаарт мэдээлнэ.

8.6. Халдварт өвчин судлалын үндэсний төв болон тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын баг сэжигтэй тохиолдол илэрмэгц шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Ес. Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа

9.1. Хууль тогтоомж болон энэ журмыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагууд хамтран ажиллана.

9.2. Энэ журмын 9.1-д заасан эрх бүхий байгууллага гэдэгт Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналтын байгууллага хамаарна.

9.3. Эрх бүхий байгууллагууд хууль тогтоомж, энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, шуурхай арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй.

Арав.Хариуцлага

10.1.Энэ журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



---оо---



ЗӨӨВРИЙН БИТҮҮМЖИЛСЭН САНАЛЫН
ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ ХҮСЭЛТ

.....овогтой.....би /РД:...../
Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай холбоотойгоор

- Тусгаарлах байранд тусгаарлагдсан
- Хэвтэн эмчлүүлж байгаа
- Гэрээр тусгаарлагдсан
- Тусгай чиг үүргийн дагуу ажиллаж байгаа

учир “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-д заасны дагуу зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлт гаргаж байна.

Оршин суугаа газрын хаяг:.....
.....
.....
.....
.....

Утасны дугаар:

Хүсэлт гаргасан сонгогч:/.....
гарын үсэг

2021 оны сарын өдөр